



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 21 өдөр

Дугаар А/308

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 "а", 29.1.3 "б", 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн "Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих жил" болгон зарлах тухай 03/06 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн "Зорилтот жилийн төлөвлөгөө батлах тухай" А/31 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Газар тариалан, үйлдвэрлэл эрхлэгчдийг туршлага судлуулах ажлыг зохион байгуулахад 6,900,000 (зургаан сая есөн зуун мянга) төгрөг, нийт мал сүрэгт эрүүл мэндийн үзлэг тандалт хийхэд 6,000,000 (зургаан сая) төгрөг, сумдын услалтын системүүдийг газар дээр нь үзэж эвдрэл, гэмтлийг тогтоох ажлын зардалд 2,000,000 (хоёр сая) төгрөгийг төгрөгийг тус тус зарцуулсугай.

2.Дээрх 14,900,000 (арван дөрвөн сая есөн зуу) төгрөгийг орон нутгийн төсөвт батлагдсан зорилтот жилийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100652

D:My Doc. Zahiramj. Zasag darga